



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 04 сарын 15 өдөр

Дугаар А119

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл ахуйн тухай хуулийг сурталчлах ажлын хүрээнд “Эрүүл, аюулгүй орчин” сэдэвт Эрүүл ахуйч-тархвар судлаачдын үндэсний гуравдугаар зөвлөлгөөнийг 2016 оны тавдугаар сарын 25-26-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Зөвлөлгөөнийг зохион байгуулах нэгдсэн удирдлага, мэдээллээр хангаж ажиллах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын хэсгийн ажиллах удирдамжийг хоёрдугаар, үйл ажиллагааны төлөвлөгөөг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Зөвлөлгөөнийг зохион байгуулахад шаардагдах зардлыг өөрийн байгууллагын хүрээнд хэрэгжиж буй олон улсын төсөл хөтөлбөр, хандив г.м санхүүжилтийн эх үүсвэрийг зохион байгуулж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч /П.Оюунцэцэг/, Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн (Б.Цогтбаатар), Халдварт өвчин судлалын үндэсний төв (Д.Нямхүү), Нийслэлийн эрүүл мэндийн газар (Ш.Энхбат), Зоонозын өвчин судлалын үндэсний төв (Н.Цогбадрах) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (С.Ламбаа)-д даалгасугай.

САЙДЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ОЮУНБААТАР


080413

Эрүүл мэнд, спортын сайдын
2016 оны 04 сарын 15 өдрийн
АМГ дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт

**“ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ ОРЧИН” СЭДЭВТ ЭРҮҮЛ АХУЙЧ-ТАРХВАР СУДЛААЧДЫН ҮНДЭСНИЙ
ГУРАВДУГААР ЗӨВЛӨЛГӨӨНИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ НЭГДСЭН УДИРДЛАГА,
МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАЖ АЖИЛЛАХ АЖЛЫН
ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

- Ажлын хэсгийн дарга: П.Оюунцэцэг, ЭМСЯ-ны Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга
- Нарийн бичгийн дарга Ш.Уранцэцэг, ЭМСЯ-ны ЭМБХЗГ-ын Орчны эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн зохицуулалт хариуцсан мэргэжилтэн
- Д.Баярболд, МХЕГ-ын ЭМБСХГ-ын Эрүүл мэндийн хяналтын хэлтсийн дарга (зөвшилцсөнөөр)
- Ажлын хэсгийн гишүүд: Э.Эрдэнэчимэг, АШУҮИС-ийн НЭМС-ийн Орчны эрүүл мэндийн тэнхимийн эрхлэгч (зөвшилцсөнөөр)
- А.Энхжаргал, НЭМХ-ийн Орчны эрүүл мэнд, хор судлалын төвийн дарга
- А.Амбасэлмаа, ХӨСҮТ-ийн Халдварт өвчин, тандалт судалгааны албаны дарга
- Ц.Отгонцэцэг, ЗӨСҮТ-ийн Мэргэжлийн тусламжийн албаны тархвар судлагч
- Ц.Ундрал, НЭМГ-ын Орчны эрүүл мэнд, осол гэмтэл хариуцсан мэргэжилтэн
- Д.Цэнд-Аюуш, НМХГ-ын Эрүүл мэнд, боловсрол, соёлын хяналтын хэлтсийн дарга (зөвшилцсөнөөр)
- В.Дэлгэрмаа, ДЭМБ-ын Орчны эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн (зөвшилцсөнөөр)
- Д.Отгонбаатар, Монголын эрүүл ахуйч, тархвар судлаачдын нэгдсэн холбооны ерөнхийлөгч (зөвшилцсөнөөр)

Эрүүл мэнд, спортын сайдын
2016 оны 04 сарын 15 өдрийн
112 дугаар тушаалын 2 дугаар



**“ЭРҮҮЛ, АЮУЛГҮЙ ОРЧИН” СЭДЭВТ ЭРҮҮЛ АХУЙЧ-ТАРХВАР СУДЛААЧДЫН
ҮНДЭСНИЙ ГУРАВДУГААР ЗӨВЛӨЛГӨӨНИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ НЭГДСЭН
УДИРДЛАГА, МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАЖ АЖИЛЛАХ АЖЛЫН
ХЭСГИЙН АЖИЛЛАХ УДИРДАМЖ**

Хэрэгцээ, шаардлага:

Эрүүл ахуйч-тархвар судлаачдын үндэсний анхдугаар зөвлөлгөөнийг 2011 онд зохион байгуулж, цаашид 2 жил тутамд хийж байх уриалгыг хэрэгжүүлэх үүднээс 2013 онд 500 гаруй төлөөлөгчид оролцсон “Эрүүл мэнд- Аюулгүй байдал” сэдэвт эрүүл ахуйч, тархвар судлаачдын үндэсний хоёрдугаар зөвлөлгөөнийг зохион байгуулсан юм.

Эрүүл мэнд, спортын яамнаас санаачлан “Эрүүл ахуйн тухай хууль”-ийг боловсруулж, Монгол Улсын Эрүүл ахуйн тухай хууль 2016 оны 2 дугаар сарын 04-ний өдөр батлагдаж, 2016 оны 2 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн улс даяар дагаж мөрдөж байна.

Үүнтэй уялдуулан уг хуулийн хэрэгжилтийг хангах, салбар дундын хамтын ажиллагааг чиглүүлэх үүднээс ухуулга, нөлөөллийн ажлыг эрүүл ахуйч, тархвар судлаачдын дунд хийх шаардлагатай байна.

Иймд “Эрүүл, аюулгүй орчин” сэдэвт эрүүл ахуйч-тархвар судлаачдын үндэсний гуравдугаар зөвлөлгөөнийг зохион байгуулах шаардлагатай байна.

Зорилго: Эрүүл ахуйн тухай хуулийг сурталчлах, ухуулга нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах чиглэлээр “Эрүүл, аюулгүй орчин” сэдвийн дор эрүүл ахуйч-тархвар судлаачдын үндэсний гуравдугаар зөвлөлгөөнийг зохион байгуулах

Хэлэлцэх асуудал ба сэдвүүд:

- Эрүүл ахуйч, тархвар судлалын салбарын өнөөгийн байдал, хамтын ажиллагаа, цаашдын чиг хандлагын талаар илтгэл хэлэлцүүлэх
- Эрүүл ахуйн тухай хуулийн танилцуулга хийж, хууль дагаж гарах баримт бичгийн төслүүдийг хэлэлцүүлэх

Зохион байгуулагч: ОМСЯ

Зохион байгуулах газар: АШУУИС-ийн НЭМС

Оролцогч байгууллагууд: УИХ, ЗГХЭГ, НЭМХ, ХӨСҮТ, ЗӨСҮТ, НЭМГ, МХЕГ, НМХГ, АШУҮИС-ийн НЭМС, ахмад настан, орон нутгийн МХГ, ОУ-ын байгууллага болон ТББ-ын төлөөлөл, нийт 300 хүн

Хугацаа: 2016 оны 5-р сарын 25-26-ны өдрүүд

Гарах үр дүн:

- Эрүүл ахуйн тухай хуулийн талаар нэгдсэн ойлголттой болж, хуулийг сурталчлах, ухуулга нөлөөллийн ажилд ахиц гарч, салбар дундын хамтын ажиллагаа идэвжинэ.

- “Эрүүл ахуйч, тархвар судлаачдын үндэсний III зөвлөлгөөн”-ийг зохион байгуулсан байна.